

**ГЛОБАЛЬЧЛАЛ БА МЕНТАЛИТЕТ**ПАВЛОВ В.И<sup>1</sup>, М.МӨНХЗУЛ<sup>2</sup><sup>1</sup> МУИС, НШУС, Философийн тэнхим<sup>2</sup> МУИС, НШУС, УТС-ын тэнхим

**Түлхүүр үг:** Глобальчлал, менталитет, локализаци, хүн төрөлхтөн, шинэ эрин үе, үндэсний эрх ашиг, метанийгэм, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хөгжлийн нөөц, үнэт зүйлс.

**Товч агуулга:** Хэдийгээр глобальчлал хэмээх үгийг бид саяхнаас сонсож байгаа мэт боловч энэхүү үйл явц нь түүхэн урьд цагт ямар нэгэн хэлбэрээр оршин байжээ гэж судлаачид үздэг юм. Глобальчлах үйл явц түүхэн замналынхаа туршид хүн төрөлхтнийг үнэт зүйлсээс татгалзах, тэдний менталитетэд нөлөөлж байдгийг өнөөгийн монголын нийгэм-эдийн засгийн байдал харуулж байна.

Эдүгээ дэлхийн улс төр, нийгмийн амьдралд өрнөж буй түүхэн бөгөөд бодит үйл явц болоод байгаа Глобальчлал хэмээх нэр томъёо олон өөрчлөлт, хувьсалт, шинэчлэлт болон олон үйл явцыг араасаа дагуулсан ихээхэн позитив ээдрээтэй олон талт үйл явц гэдгийг хэн бүхэн мэднэ. Глобальчлалын талаарх үзэл баримтлал олон утга санаатай байгаа бөгөөд улс орнуудын эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд явж буй янз бүрийн хандлага чиглэлтэй байгаа асуудал юм. Нийтээр даяарших үйл явц нь түүхэнд урьд хожид ч байсан. Энэ үйл явцын хамгийн онцлог шинж нь аль нэг орны юмуу, хэн нэгэн хүний эрх ашгийг илэрхийлсэн, өөрөөр хэлбэл хүн төрөлхтний нэгдэн нийлэх үйл явцыг өөрийн үндэсний эрх ашгийн урсгалд чиглүүлэх, өрсөлдөх чадвараа хүчтэй болгоход ашиглах санаа агуулж байгаа.

Глобальчлал ор нь олон зуун жилийн турш хөгжиж буй түүхэн үйл явц мөн. Шинжлэх ухааны ном зохиолд "Менталитет" хэмээх ойлголт – XIX зууны эхээр, "Глобальчлал" хэмээх ойлголтыг XX зууны сүүлийн хагасаас хэрэглэж эхэлсэн. Хэдий тийм боловч хүн төрөлхтөн бий болсон үеэс эхлэн энэхүү хоёр ойлголтуудын агуулгыг бүрэн хэмжээгээр илэрхийлээгүй ч "глобальчлал", "менталитет" хэмээх ойлголтыг бүрэлдүүлдэг хэсгүүд нь түүхэнд ямар нэгэн хэмжээгээр оршиж байв. Тухайлбал, Чингис хаан Монгол улсыг нэгтгэн засаг захиргааг тогтоож, 3 түмэнд хувааж өөр өөрийн удирдах зарчимтай болгосон нь монголын түүхийн хөгжилд түлхэц өгсөн юм. Харин өнөө үед Чингис хааны авсан арга хэмжээг бүсчлэх (локализация) үйл явцын илрэл гэж болох бөгөөд энэ нь глобальчлалын нэг хэсэг болдог гэж үзэх үндэстэй.

Хүн төрөлхтний түүхийн хөгжлийн эрин үе нь шинэ он тоололтой давхардах, давхарддаггүй ч үе байдаг юм. Тухайлбал, XXI зууныг он тооллын хувьд хүн төрөлхтний хөгжлийн шинэ эрин үе эхэлсэн гэж үзэж болохгүй юм. Харин Монгол улсын хувьд бол XIII, XX, XXI зуунуудыг он тооллын хувьд түүхийн хөгжлийн шинэ эрин үетэй ерөнхийдөө давхардсан гэж үзэж болох бөгөөд уг хугацаанд Монголын нийгэм улс хэд хэдэн удаа шинэчлэгдэж байжээ.

Их Монгол улс байгууллагдах үе, манжийн түрэмгийлэл болон шарын шашин Монгол улсад нэвтрэн орсон үе, Монгол Ардын Хувьсгал ялсан үе, XX зууны 1990 оны ардчилсан хувьсгалын үе үндсэндээ Монгол улсын түүхийн хөгжлийн хувьд шинэ эрин үетэй давхардсан гэж үзэж болно, харин монгол угсаатны менталитетийн нийгэм-соёлын үндсүүд нь "монголын нийгмийн хөгжилд саад тотгор болж байсан олон аймгуудын хоорондын олон жилийн тасралтгүй аян дайн намжиж, саланга тасархай байдлыг эцэс болгосон ба Монгол угсаатны бүрэлдэн тогтох үндсийг бүрэлдүүлж, төр улс, ахас ихэсээ дээдлэн хүндлэх, тэдний үг сургаалийг үеийн үед хадгалж [1]. "Монгол өв уламжлал" бүрэлдэн тогтсон гэж үздэг.

Хүн төрөлхтөн бие биенээсээ тусгаарласан үндэс-угсаатны нэгдмэл бус байдлаас хамааран дэвшилтэд хүрэх түүхэн бодит ба нийгэм-эдийн засгийн адил бус нөхцлөөр хангагдсан байдаг. Энэ нь зарим тохиолдолд нэг талаас хурдтай, нөгөө талаас, удаашралтай, өөрөөр хэлбэл, янз бүрийн үндэс – угсаатны нэгдлүүдийн ижил бус нийгэм-эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог учраас "уг нэгдлүүд бусдад хохиролтойгоор буюу бусдын ачаар хөгжих оролдлогыг заавал хайдаг, бөгөөд олсноос хойш, улам гүнзгийрүүлэх талаар арга хэмжээ авдаг" [2] юм. Үүний нэг илэрхийлэл бол Чингис хаан болон түүний өв залгамжлагчид 1208 оноос хойш хийсэн аян дайн, эдийн засаг, худалдаа, мал аж ахуй, шашин, төрийн талаар баримталж байсан үзэл бодлууд мөн. Дээрх жишээ нь дараах байдлыг мөн нотолж байгаа гэж үзэж байна. Глобальчлалын үйл явцын гол хандлага бол өөрийн өвөрмөц шинжтэй локаль нийгмүүдийг өөртөө шингээн метанийгмийг бүрэлдүүлэх зорилготой оршдог юм. Гэвч локаль нийгмүүдийн өвөрмөц шинжүүдийг дутуу үнэлснээс буюу үл тоосноос болж, энэ зорилго нь эдийн засгийн түрэмгийлэл, тус орнуудын байгалийн баялагийг эзэмших зорилт болж хувирч байдаг ажээ. Энэ хувиралт нь тодорхой аюул агуулдаг учраас "үндэсний дэвшилт хүчний бүрэлдэхүүнд хаад, ноёд, жирийн ард, шинээр үүсч буй баян чинээлэг хүмүүсийн бүх л анги бүлгийг хамарсан

[3]. улс орноо сэргэн мандуулья гэсэн хөдөлгөөн үүсч, “эх оронч үзлийн илэрхийлэл болж, үндэсний тусгаар тогтнолыг сэргээн, газар нутгийнхаа эзэн болох нэгдмэл санаа бий болгодог» юм. Өөрөөр хэлбэл нийгмийг бүрэлдүүлдэг бүх бүлгүүдийн менталитетэд гүн шингэсэн эх оронч үзэл нь Их Монгол гүрнийг бутралд хүргэсэн. Цаашилбал, энэ байдалд Манжийн гүрэн, Фашист Герман, ЗСБНХУлсын социалист интеграци орсон юм.

Эндээс глобальчлал гэдэг нь жинхэнэ утгаараа бол аливаа улс үндэстэн хөгжил дэвшлээрээ аяндаа, жам ёсоороо нэгдэн нийлэх үйл явц байх ёстой болохоос биш дээр дурьдсанчлан хүчээр, түрэмгийлэх замаар хийгдэх учиргүй гэдгийг түүх харуулсан. Харин ХХ зууны сүүл үеэс дэлхий даяараа “Глобальчлал” гэсэн нэр томъёог өргөн хэрэглэх болсон. Тэгвэл энэхүү глобальчлалын эрин үе дэхь хошуучлагч орныг АНУ гэж хэлж болохоор байна. Хэдийгээр глобальчлал гэдэг нь техник технологи, хөгжил дэвшлийн ойртон нягтрах үйл явц мөн гэдгийг хэн ч үгүйсгэх аргагүй ч энд уг үйл явцаар хаацайлсан засаглалын төлөөх тэмцэл явагдаж байна гэж бид үзэж байгаа. Тодруулж хэлбэл, Америкжих процесс бий болоод байгаа юм болов уу гэсэн болгоомж төрүүлж байна. Тийм учраас энэ эрин үед ядуу буурай орнууд тодруулбал, монголчууд бид өөрсдийн өв соёл, үндэсний аюулгүй байдлаа яаж, юугаараа авч үлдэх талаар бодолцох хэрэгтэй болжээ. Юуны өмнө нэн чухал зүйл болох оюуны аюулгүй байдлаа бид дээд зэргээр хангах ёстой. Оюуны аюулгүй байдалд үндэсний ухамсар, үндэсний шашин, соёл, боловсрол зэрэг багтаж буй.

Монголчууд бид амраар нь өнгөн соёлыг их хөгжүүлж буй мэт харагдаж байна. Тэгвэл түүхэн урт удаан хугацааны туршид биднийг монгол төрхөөр нь хадгалж байсан олон зүйл дотроос хамгийн чухал нь сэтгэлийн гүний соёл гэж хэлж болно. Хөгжилтэй, Их гүрнүүдийг хуулбарлан дуурайх биш өөрийн онцлогийг харгалзан соёлын үнэт зүйлсээ авч үлдэх хэрэгтэй байна. Энэ бүхэнд дээр дурьдсан бүгдийн нийлмэл цогц болох менталитет чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэтэл өнөөдөр монголчуудын менталитет хямралын байдалтай байна. Хэдийгээр аливаа салбарт бий болсон хямрал нь шилжилтийн тодорхой үед үргэлжилж аажимдаа зогсонги хандлагатай байдаг ч өнөөгийн монголчуудын менталитетийн хямрал нэлээд удаан хугацаанд үргэлжлэх шинжтэй байна. Нэг ёсондоо шилжилтийн үеийн нийгэмд амьдарч буй бидний менталитет бүхэлдээ тодорхой бус байгаа юм. Уг асуудлыг монголчуудын нийгмийн парадигмын асуудал дээр ч адилтган үзэж болох билээ” [4]

Ерөөс хямралын үеийн менталитет гэдэг бол хүмүүсийн үйл байдал, ухамсарын бүтэц болон сэтгэцийн бүхэлд нь тодорхой байсан нийгэм улс төрийн тогтвортой бүрдэл уналтын байдалд орсон тэр зурвас үеийг хэлдэг байна. Хямралын үеийн менталитетыг зарим үед "нэгдэлгүй ухамсар" гэх нь бий. Аливаа ард түмэн, үндэсний менталитетын онцлог нь тэдний шүтэж байгаа шашин, баримталж буй үзэл, геополитикийн нөхцөл байдлаар илрэн гардаг.

Менталитет бол нийгмийн хөгжлийн нөөц гэж хэлж болох юм. Нийгмийн шинэчлэлийн ямарч үйл явц хүний менталитет, түүний сэтгэл зүй, бодит шаардлага болсон шинэлэг зүйлийг нийгмийн үүднээс мэдрэх чадвараас эхэлж байдаг юм. Нийгмийн системд таарсан хүний менталитет бий болоогүй тохиолдолд нийгмийг хөгжүүлэхэд авч байгаа арга хэмжээ нь зохих хэмжээгээр үр дүнгүй байдгийг өнөөдрийн нийгмийн нийгэм-эдийн засгийн байдал харуулж байна. Өөрөөр хэлбэл, энэ асуудлыг холбон дараах байдлаар тайлбар хийж болмоор байна.

Глобальчлал нь нийгмийн хөгжлийн үйл явц бол менталитет нь нийгмийнхөгжлийн нөөц нь гэж хэлж болох юм. Иймд энэ хоёр ойлголт хоорондоо нарийн холбоотой байдаг. Дээр өгүүлснээр уг үйл явцын зорилго локаль нийгмийн өвөрмөц шинжийг дутуу үнэлснээс буюу үл тоомсорлосон байдалтай хандвал глобальчлал менталитет хоёр зөрчилдөж глобальчлалын түрэмгийлэх хэлбэр нь бутрах, зогсонги байдалд орох г.м. олон талын сөрөг үр дагавар бий болгодог юм. Нөгөө талаас глобальчлалын шинэлэг зүйл, эерэг олон тал байдаг хэдий ч (манай орны хувьд) ардчилах үйл явц нь менталитетийг шинэчлэхийг шаарддаг учраас үр дүн удаан гардаг. Тухайлбал, Монгол улс зах зээлийн эдийн засагт орсноор хувийн өмч хуримтлах үе шатаар хоёр дахь удаагаа дамжин өнгөрөх шаардлагатай болж байгаа ба энэ нь менталитетийг шинэчлэх буюу сэргээх шаардлагыг бий болгож байгаа юм. Ер нь аливаа нийгэм нэгээс нөгөөд тухайлбал, тоталитаризмээс [хаалттай] ардчилсан [нээлттэй] нийгэм уруу шилжихэд эдийн засаг, улс төр, соёл болон нийгмийн сэтгэл зүйн аль ч төвшин хүрээнд хямрал гаргахад хүрдэг" [5] Өөрөөр хэлбэл, монгол угсаатны менталитет түүхийн хөгжлийн явцад ялангуяа шинэ эрин үеийн эхлэх үед хямарч шинэчлэгдэж байсан юм.

XXI зуун дахь глобальчлалын эрин үеийн Монголчуудын менталитетын глобальчлалтай шинэчлэл (трансформац) нэлээд урт хугацааны турш үргэлжилж байгаагийн учир шалтгааныг юуны өмнө бид

өмнөх менталитетаас татгалзахад бэрхшээлтэй байгаа, хоёрдугаарт, өмнөх үнэт зүйлсээс хэтэрхий яаруу татгалзсанаас үүдэн **деструктив** [6] үр дагаварууд бий болж, энэ нь нийгэм-эдийн засгийн хөгжилд саад бэрхшээл учруулж байна. Нөгөө талаас, нүүдлийн сэтгэлгээтэй монголчуудад социалист үзэл суртлын нөлөөний улмаас өөрийн менталитетээ шинэчлэхэд нэлээд их цаг хугацаа шаардсан бөгөөд энэ нь өнөөгийн хямралын үед удаан хугацаагаар оршин тогтнох талтай байна.

### Резюме

Сегодня много говорят и пишут о глобализации как социальном феномене, о возможных последствиях её осуществления, о глобалистике, пытающейся осмыслить и исследовать данный феномен. Наши размышления прежде всего были направлены на выявление форм проявления глобализма в течение существования человеческой цивилизации.

Известно, что общество есть объединение людей, живущих совместно исторической жизнью. В истории человечества существовало и ныне существует множество видов обществ, отличающихся друг от друга по размерам территории, по качеству и количеству населения, по типу внутренней и внешней индентификации, по характеру культуры, религии, идеологии, по сфере государственности и экономики, по уровню социальной организации и цивилизованности, по системе власти и управления и многим другим характеристикам. Но несмотря на эти отличия каждое объединение людей обладает своим внутренним особенным менталитетом, который до настоящего времени называли то "духом народа", то "характером народа" или "национальным сознанием" и т.д. Наступление новой эпохи для той или иной цивилизации всегда сопровождался пересмотром ценностей, но не полным от неё отказом, и изменением менталитета.

1. Ж.Заанхүү, Т.Алтанцэцэг "Монголын түүхийн лекцүүд", УБ., 1999,  
56 дахь тал
2. "Социально-гуманитарные знания". Орехово-Зуево 3' 2002, с. 9
3. Ж.Заанхүү, Т.Алтанцэцэг "Монголын түүхийн лекцүүд", УБ., 1999,  
221 дэх тал
4. "Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд" Цуврал № 4, УБ., 1998,  
95 дахь тал
5. Мөн тэнд
6. Мөн тэнд